



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар A/07

Улаанбаатар хот

**“Багахангай дүүргийн шагналын төрөл,
түүнийг олгох журам”-ыг шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.18 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналын төрөл, түүнийг олгох журам”-ыг шинэчлэн нэгдүгээр, шагналд нэр дэвшигчийн анкетын загварыг хоёрдугаар, “Багахангай дүүргийн оны шилдэг байгууллага, ажилтан шалгаруулах журам”-ыг гуравдугаар, “Оны шилдэг байгууллага”-ыг шалгуур үзүүлэлтээр дүгнэх аргачлалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням), Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Санжийжамц) нарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2023 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн
1107 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ШАГНАЛЫН ТӨРӨЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дүүргийн бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулсан, дүүргийн удирдлагаас нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэрийг биелүүлэхэд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан төр захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагч, иргэдийг идэвхжүүлэн шагнаж урамшуулахтай холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,
Засаг даргын шагналын төрөл

2.1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Засаг даргын хамтарсан шагнал

2.1.1.Хүндэт иргэн, 500,000 төгрөг (таван зуун мянга) төгрөг

2.1.2.“Хүндэт тэмдэг”, 100,000 (нэг зуун мянга) төгрөг

2.1.3.“Талархал”, дурсгалын зүйл

2.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал

2.2.1.Хүндэт өргөмжлөл, 50,000 (тавин мянга) төгрөг

2.2.2.Хүндэт үнэмлэх, 30,000 (гучин мянга) төгрөг

2.3.Дүүргийн Засаг даргын шагнал

2.3.1.Жуух бичиг, 30,000 (гучин мянга) төгрөг

Гурав. Шагналд нэр дэвшигчид тавигдах шаардлага

3.1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Засаг даргын хамтарсан шагнал “Хүндэт иргэн”

Дүүргийн хөгжил цэцэглэлт, төрийн бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж үр бүтээлтэй ажилласан, салбартаа нэр хүндтэй, ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн, тухайн салбартаа шинэ нээлт бүтээл гаргасан, олон улсын чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан, орон нутагтаа шинийг санаачлан ашигтай загварын гэрчилгээ, патент авч практикт нэвтрүүлсэн, улсад 20-оос доошгүй жил ажилласан иргэнийг шагнаж урамшуулна.

3.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Засаг даргын хамтарсан шагнал “Хүндэт тэмдэг”

Дүүргийн хөгжил цэцэглэлт, төрийн бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж улсад 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, салбартаа нэр хүндтэй, ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн албан хаагчдыг шагнаж урамшуулна.

3.3.Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, дүүргийн Засаг даргын хамтарсан шагнал “Талархал”

Дүүргийн нэрийг Олон улс, улс, нийслэлд гаргаж, онцгой амжилт үзүүлсэн иргэн, албан хаагч, баг, хамт олныг шагнаж урамшуулна.

3.4.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал “Хүндэт өргөмжлөл”

Дүүргийн хөгжил цэцэглэлтэд онцгой хувь нэмэр оруулсан, салбартаа нэр хүндтэй, ажил хөдөлмөрөөр тэргүүлсэн, улсад 5-аас доошгүй жил ажилласан дүүргийн иргэнийг шагнаж урамшуулна.

3.5.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал “Хүндэт үнэмлэх”

Дүүрэгт болон тухайн байгууллагад 3-аас доошгүй жил ажил хөдөлмөрөөрөө хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж, дүүрэг орон нутгаа хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан иргэд, албан хаагчдыг шагнаж урамшуулна. (Улс, нийслэлд онцгой амжилт гаргасан тохиолдолд жил харгалзахгүй байж болно)

3.6.Дүүргийн Засаг даргын шагнал “Жуух бичиг”

Дүүрэгт болон тухайн байгууллагад 3-аас доошгүй жил ажил хөдөлмөрөөрөө хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж, дүүрэг орон нутгаа хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан иргэд, албан хаагчдыг шагнаж урамшуулна.

Дөрөв.Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1.Шагналд нэр дэвшүүлэх хүсэлтийг тухайн иргэний ажиллаж, суралцдаг байгууллагын удирдлага (ажиллаж байгаа, ажиллаж байсан), иргэдийг хорооны Засаг дарга тодорхойлно.

4.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг дарга иргэд, албан хаагчдыг нэр дэвшүүлэн шагнаж болно.

4.3.Нэр дэвшигчид дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

4.3.1.Тухайн байгууллагын хүсэлт;

4.3.2.Нэр дэвшигчийн анкет, мэдүүлэг, зурагтай;

4.3.3.Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;

4.3.4.Хамт олны хурлын тэмдэглэл;

4.3.5.Онцгой амжилт гаргасан бол энэ тухай танилцуулга;

4.3.6.Дараагийн шатны шагналаар шагнагдах бол өмнөх шагналын хуулбар;

4.3.7.Иргэний үнэмлэхийн хуулбар;

4.3.8.Хорооны тодорхойлолт.

4.4.Шагналд нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын амжилт, авьяас чадвар, оруулсан хувь нэмрийг товч тодорхой бичиж, холбогдох судалгаа, үзүүлэлтийг хавсаргасан байна.

4.5.Дээрх материалыг бүрдүүлэн тэмдэглэлт үйл явдал болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.

4.6.Материалыг хугацаа хожимдуулсан, нэр дэвшигчийн тодорхойлолтыг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн, шагналд нэр дэвшүүлэх болзол хангаагүй материал ирүүлсэн тохиолдолд шагнал олгох асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд материалыг ирүүлсэн байгууллагад буцаана.

Тав.Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, гардуулах

5.1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулах материалыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд, дүүргийн хамтарсан

шагналаар болон дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулах материалыг Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

5.2.Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагнуулах тухай хүсэлт, материалыг хянан, шаардлага хангасан иргэний материалыг удирдлагад танилцуулж тогтоол, захирамжаар шийдвэрлүүлнэ.

5.3.Шагналыг түүхэн ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг дарга гардуулна.

5.4.Шагналыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Засаг даргын орлогч, Хурлын Ажлын албаны дарга, Засаг даргын Тамгын газрын дарга болон тэмдэглэлт үйл явдалд урилгаар оролцож байгаа зочид төлөөлөгчид гардуулж болно.

5.5.Хамтарсан шагналыг дүүргийн “Баяр наадам”-ын үеэр болон “Талархал”-ыг тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан гардуулна.

5.6.Өмнө авсан шагналаас хойш ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс ахисан тохиолдолд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ. Шагнал хоорондын зай 2-оос доошгүй жил байна.

5.7.Шагналыг олгохдоо доороос дээш нь өгсүүлэх зарчмыг баримтална.

5.8.Онцгой амжилт гаргасан тохиолдолд шагналыг хугацаанаас нь өмнө болон алгасуулан олгож болно.

Зургаа.Шагналын мэдээллийн сан

6.1.Дүүргийн шагналын төрөл, огноогоор төрөлжүүлсэн шагнагдсан хүмүүсийн цахим мэдээллийн санг бүрдүүлж, ашиглана.

6.2.Мэдээллийн санд бүртгэгдсэн дугаар нь тухайн шагналын үнэмлэхний дугаар байна.

6.3.Дүүргийн “Хүндэт иргэн” шагналаар шагнагдаж “Хүндэт дэвтэр”-т бичигдэх иргэдийн мэдээллийн санг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бусад хамтарсан шагналын болон дүүргийн Засаг даргын шагналын мэдээллийн санг Засаг даргын Тамгын газар хариуцан хөтөлнө.

Долоо.Төрийн шагналд уламжлах

7.1.Төрийн одон медалиар шагнуулах иргэдийн материалыг дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх бөгөөд шагнал хариуцсан мэргэжилтэн судалж, шаардлага хангасан материалыг дүүргийн Засаг даргад танилцуулан Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлах асуудлыг шийдвэрлүүлнэ.

7.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн төрийн шагналын материалыг хүлээн авч хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоол гарган холбогдох газарт уламжилна.

Найм.Бусад зүйл

8.1.Шагналын зардлыг жил бүрийн төсөвт тусган холбогдох зардлаас санхүүжүүлнэ.

8.2.Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн
1107 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

- 1.Овог
- 2.Нэр:
- 3.Төрсөн огноо:
- 4.Нас, хүйс:
- 5.Регистр:
- 6.Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг:
- 7.Одоогийн харьяалал (Хаяг бүтнээр бичнэ):
- 8.Боловсрол:
- 9.Мэргэжил:
- 10.Ажилладаг салбар:
- 11.Урьд ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа байгууллага:

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа	Албан тушаал
1			
2			
3			
4			

- 12.Дүүрэгт ажиллаж амьдарсан хугацаа:

Улсад ажилласан жил:

Тухайн салбарт ажилласан жил:

Тухайн байгууллагад ажилласан жил:

- 13.Урьд шагнагдсан дүүргийн болон бусад шагнал (он дарааллаар):

№	Шагналын нэр	Шагнагдсан он
1		
2		
3		

- 14.Шагнуулах үндэслэл, ажлын үзүүлэлт (товч тодорхой бичнэ):

.....
.....
.....
.....

- 15.Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

- 16.Хамт олны саналын хувь:

- 17.Утасны дугаар:

Тодорхойлолт гаргагч байгууллагын
дарга захирал-ын гарын үсэг, тамга, тэмдэг
оны сарынны өдөр

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 1025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн
А/07 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагч, иргэдийн тухайн жилийн хөдөлмөр бүтээл, амжилтыг урамшуулан дэмжиж, иргэдэд сурталчлан алдаршуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Дүүргийн оны шилдэг байгууллага,
ажилтан шалгаруулах төрөл

2.1.Дүүргийн оны шилдэг байгууллага, ажилтан нь дараах төрөлтэй байна.

- 2.1.1.Оны шилдэг байгууллага;
- 2.1.2.Төрийн байгууллагын шилдэг ажилтан;
- 2.1.3.Нийгмийн салбарын шилдэг ажилтан;
- 2.1.4.Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний шилдэг ажилтан;
- 2.1.5.Дэд бүтэц, нийтийн аж ахуйн шилдэг ажилтан;
- 2.1.6.Төмөр замын шилдэг ажилтан;
- 2.1.7.Сайн малчин;
- 2.1.8.Шилдэг залуу;
- 2.1.9.Шилдэг оюутан;
- 2.1.10.Оны онцлох сурагч. (Сурлага, урлаг, спорт)

Гурав.Шагналын дагалдах мөнгөн урамшуулал

3.1.Шагналд дараах мөнгөн урамшууллыг дагалдуулан олгоно.

- 3.1.1.Оны шилдэг байгууллага 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг
- 3.1.2.Төрийн байгууллагын шилдэг ажилтан 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.3.Нийгмийн салбарын шилдэг ажилтан 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.4.Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний шилдэг ажилтан 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.5.Дэд бүтэц, нийтийн аж ахуйн ажилтан 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.6.Төмөр замын шилдэг ажилтан 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.7.Сайн малчин 500,000(таван зуун мянга) төгрөг дурсгалын зүйл
- 3.1.8.Шилдэг залуу 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.9.Шилдэг оюутан 500,000 (таван зуун мянга) төгрөг
- 3.1.10.Оны онцлох сурагч 500,000 (таван зуун мянга) төгрөг

3.2.Дагалдах мөнгөн шагналыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргана. Шагналын зардлыг жил бүрийн төсөвт тусган холбогдох зардлаас санхүүжүүлнэ.

Дөрөв.Оны шилдэг байгууллага, ажилтан шалгаруулах төрөлд хамаарах салбар, Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл

4.1.Оны шилдэг байгууллага:

Тухайн жилд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтыг бүрэн биелүүлсэн, менежментийн шилдэг шийдлийг нэвтрүүлсэн, татвар төлөлтийг бүрдүүлсэн, нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой ажил санаачилж хийсэн, албан хаагчдыг сургаж, хөгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөлийг бүрдүүлж, тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр хийсэн ажил, журамд заасан болзол шалгуурыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага

4.2.Төрийн байгууллагын шилдэг ажилтан

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын газар, Дотоод Аудитын алба, Худалдан авах ажиллагааны алба, Газар зохион байгуулалтын алба, Боловсролын хэлтэс, Улсын Бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Мал эмнэлгийн тасаг зэрэг байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчид

4.3.Нийгмийн салбарын шилдэг ажилтан

Ерөнхий боловсролын 91-р сургууль, 94-р сургууль, Сургуулийн өмнөх боловсролын 44, 207, 183-р цэцэрлэг, Насан туршийн суралцахуйн төв, Эрүүл мэндийн төв, Соёлын ордон, Биеийн тамир спортын хороо, Төмөр замын их эмчийн салбар, дүүргийн нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн ажилтан албан хаагчид

4.4.Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний шилдэг ажилтан

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв, Багахангайн Үйлдвэрлэл технологийн парк ХК, төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагын нягтлан бодогч, нярав, бичиг хэргийн ажилтан, жолооч, үйлчлэгч ажилтан албан хаагчид, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчийн үйлдвэр, худалдаа, үйлчилгээний байгууллага болон жижиг дунд бизнес эрхлэгчид

4.5.Дэд бүтэц, нийтийн аж ахуйн шилдэг ажилтан

Дулаан, эрчим хүч, барилга, орон сууц, усан хангамж, тохижилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Илч-Орд ОНӨААТҮГ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ, Ус суваг ашиглалтын товчоо, Налайх Эрчим хүчний Өндөртолгой хэсэг, Багахангайн Теле камерын хяналтын дэд төв, Сууц өмчлөгчдийн холбоодын ажилтнууд

4.6.Төмөр замын шилдэг ажилтан

Төмөр Замын салбарт ажиллагсад-Багахангай өртөө, Техник үйлчилгээний газар, Замын 17 дугаар хэсэг, Дохиолол холбооны 2 дугаар анги, Татах хэсэг, Эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр анги, Барилга, засвар, ашиглалт үйлчилгээний ангийн Багахангай хэсгийн, албан хаагчид

4.7.Сайн малчин

Дүүргийн харьяалалтай малчид

4.8.Шилдэг залуу

Дүүрэгт оршин суугчаар хаягийн бүртгэлтэй 35 хүртэлх насны залуучууд

4.9.Шилдэг оюутан

Дүүргийн харьяат, сурлага, урлаг, спортод онцгой амжилт гаргаж, дүүрэг орон нутгийн нэрийг улс, нийслэл, олон улсын хэмжээнд өндөрт өргөж, их дээд сургуульд 3.0-аас дээш голч дүнтэй суралцаж байгаа өдрийн ангийн оюутан

4.10.Оны онцлох сурагч

Дүүрэгт 3-аас доошгүй жил амьдарсан, дүүргийн Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг, сурлага, урлаг, спорт, соёл хүмүүжлээр тэргүүлсэн сурагч

Тав.Нэр дэвшигчийн бүрдүүлэх материал

5.1.Дүүргийн “Оны шилдэг байгууллага”-д өрсөлдөх аж ахуйн нэгж, байгууллага дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

5.1.1.Байгууллагын тухайн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээг шалгуур үзүүлэлт тус бүрээр тайлагнасан тайлан;

5.1.2.Татварын өргүй тухай дүүргийн Татварын хэлтсийн тодорхойлолт;

5.1.3.Албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт;

5.1.4.Цахилгаан, дулаан, усны өр төлбөргүй тухай холбогдох байгууллагын тодорхойлолт.

5.2.Дүүргийн “Шилдэг ажилтан”-д өрсөлдөх иргэн дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

5.2.1.Тухайн байгууллагын хүсэлт; (албан бичгээр)

5.2.2.Нэр дэвшигчийн анкет, зурагтай; (Батлагдсан загварын дагуу)

5.2.3.Ажил байдлын тодорхойлолт;

5.2.4.Хамт олны хурлын тэмдэглэл;

5.2.5.Тухайн онд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу гаргасан (зурагжуулсан) тайлан;

5.2.6.Өмнө авсан шагналын хуулбар;

5.2.7.Дүүрэгт амьдарсан хугацааг тодорхойлсон хорооны тодорхойлолт;

5.2.8.Дүүргийн оршин суугаа газрын лавлагаа /И-монголиагаас/

5.2.9.Иргэний үүргийн биелэлт; (цахилгаан, дулаан, сөх, усны өр төлбөргүй тухай холбогдох байгууллагын тодорхойлолт)

5.2.10.Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт (Тээврийн хэрэгслийн зөрчил хамаарахгүй)

5.3.Дүүргийн шилдэг байгууллага, ажилтанд нэр дэвшигч нь ажлын амжилт, үр дүнг товч тодорхой харуулсан цахим танилцуулга бэлтгэн ирүүлнэ.

Зургаа.Материал хүлээн авах, шалгаруулах

6.1.Дүүргийн шилдгээр шалгаруулахаар тодорхойлсон байгууллага, иргэдийн материалыг энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу 1 хувь бэлтгэн тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

6.2.“Оны онцлох сурагч”-д нэр дэвшүүлэхдээ номинаци тус бүр 3-аас доошгүй сурагчийн тодорхойлолт, холбогдох материалыг ирүүлнэ.

6.3.Дүүргийн Сайн малчин, Шилдэг оюутан, Шилдэг залууд нэр дэвшүүлэх (байгууллагад харьяалалгүй) тодорхойлолт, холбогдох материалыг хороод ирүүлнэ.

6.4.Материалыг хугацаа хожимдуулсан, нэр дэвшигчийн тодорхойлолтыг дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн, шагналд нэр дэвшүүлэх болзол шалгуурыг хангаагүй хүнийг нэр дэвшүүлсэн тохиолдолд материалыг хүлээн авахгүй бөгөөд

6.5.Шалгаруулалтын бэлтгэл хангах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулах ба ажлын хэсэг ирүүлсэн материалыг нягтлан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, Ажлын албаны дарга болон дүүргийн Засаг даргын удирдлагын Зөвлөлийн гишүүдээс бүрдсэн өргөтгөсөн хуралдаанаар 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.7. Оны шилдэг байгууллага, ажилтан шалгаруулахдаа нэр дэвшигчдийн товч танилцуулгыг дүүргийн цахим хуудаст ажлын 3 хоног байршуулан иргэд, олон нийтээс цахимаар саналыг авч шалгуурын нэг үзүүлэлт болгоно.

7.1.Дүүргийн тухайн оны шилдэг байгууллага, ажилтныг дараах шалгуур үзүүлэлтээр шалгаруулж, шалгуур үзүүлэлт тус бүрийг 10 хүртэл оноогоор, эцсийн дүнг шалгуур үзүүлэлтүүдийн нийлбэрийн дундаж оноогоор үнэлж дүгнэнэ.

№	Нэр дэвшигч байгуул- лага																						
1	Байгуул- лага	10	Тухайн жилд хийсэн ажлын үзүүлэлт, үндсэн үүрэг, улс эх орон, дүүрэгт оруулсан хувь нэмэр	10	Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал, санхүүгийн болон аудитын зөрчилгүй дүгнэгдсэн байх, татварын өргүй байх	10	Дүүргийн хэмжээнд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсэн, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	10	Хууль тогтоомжийн хэрэгжилт, Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт	10	Салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаанд оролцсон байдал, гаргасан амжилт	10	Төхижилт, ногоон байгууламж, орчны аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажил	10	Шинэлэг бүтээлч ажил	10	Хамт олны сахилга хариуцлага. ёс зүй, дэг журмыг баримталж, гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй байх	10	Дүүрэг, орон нутгийн зүгээс зохион байгуулсан арга хэмжээнд хамт олноороо оролцсон байдал	10	Цахим санал асуулгын дүн	100	Нийт үнэлгээ

7.1.2.Дүүргийн шилдэг ажилтан:

[illegible]

7.1.3.Дүүргийн “Сайн малчин”

	№	Нэр дэвшигчийн овог нэр	Хөдөлмөрийн амжилт гаргасан байдал	Малын үүлдэр, угсааг сайжруулсан байх, мал сүргийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байдал	Малын тоо толгойг өмнөх оноос нэмэгдүүлсэн талаарх “А” дансны лавлагаа	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан байдал	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил	Дүүрэгт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж амьдарсан байх	Иргэний үүргийн биелэлт	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт	Гэмт хэрэг, хэв журмын зөрчилд холбогдоогүй байх	Цахим санал асуулга	Нийт үнэлгээ
	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	100

7.1.4.Шилдэг оюутан, Оны онцлох сурагч

№	Нэр дэвшигчийн овог нэр	Тухайн онд гаргасан амжилт	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил	Ёс зүйн болон сахилгын зөрчил гаргаагүй байх	Гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй байх	Дүүрэгт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан, байх	Дүүрэг орон нутгаас зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцсон байдал	Цахим санал асуулга	Шинээр санаачилсан ажил	Өөрийгөө хөгжүүлсэн байдал	Нийт үнэлгээ
1.		15	10	10	10	10	15	10	10	10	100

Найм.Шагналын журам

8.1.Дүүргийн “Сайн малчин”-ы шагналыг Монголын уламжлал цагаан сар “Сар шинийн баяр”-ын үеэр гардуулна.

Ес.Бусад зүйл

9.1.Дүүргийн оны шилдэг байгууллага, ажилтнаар шалгарсан хамт олон, иргэнд гардуулах өргөмжлөл, үнэмлэх, туузад дүүргийн сүлд, тэмдгийг хэрэглэнэ.

9.2.Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 1107 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

ДҮҮРГИЙН ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА ШАЛГАРУУЛАХАД ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

Шалгуур үзүүлэлтүүд

Тухайн чиглэлээр ажил хийгдэж эхлээгүй бол	Тухайн чиглэлээр төлөвлөгөө боловсруулагдсан, ажил эхлүүлсэн бол	Тухайн чиглэлээр хийгдэж байгаа ажлын тал нь хийгдсэн	Тухайн чиглэлээр хийгдэж байгаа ажлын дийлэнх нь хийгдсэн бол	Тухайн чиглэлээр хийгдэж байгаа ажил дуусах шатандаа бол	Бүрэн хийгдэж дууссан бол
10 хүртэл оноо	30 хүртэл оноо	50 хүртэл оноо	70 хүртэл	90 хүртэл оноо	100 оноо